



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018. 09. 25 № 40

Асуулга тавих тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заажээ. Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт Үндсэн хуулийн дээрх хэсгийг иш болгож, Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлсон байна.

Гэвч сүүлийн үед Монгол Улсын Засгийн газар төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг алдагдуулж, хууль зөрчсөн шийдвэрүүдийг ар араас нь гаргасаар байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбат 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн "Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай" 12 дугаар захирамжаар Лхагвасүрэнгийн Ганболдыг Хөвсгөл аймгийн Засаг даргаар томилохдоо Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2-т заасан Засаг даргад нэр дэвшигч нь "төрийн албанц 3-аас доошгүй жил ажилласан байх" гэсэн заалтыг зөрчиж, томилсон.

Уг асуудлаар нэр бүхий иргэн Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасны дагуу 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаан хуралдаж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчсөн байх тул хүчингүй болгох дугаар 02 дугаар тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаас гаргасан билээ.

Гэвч Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх Та Монгол Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдааны шийдвэрийг үл тоон, хууль зөрчиж, төрийн албанц ажиллаж байгаагүй Лхагвасүрэнгийн Ганболдыг 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 136 дугаар захирамжаар Хөвсгөл аймгийн Засаг даргаар дахин томилсон байна.

Иймд дээрх хууль зөрчиж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдааны 2018 оны 02 дугаар тогтоол гарч, Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн "Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай" 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн хүчингүй болгосоор байтал дахин хууль зөрчин Л.Ганболдыг томилж буй асуудлын талаар;
2. Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 506 дугаар шийдвэрээр иргэн Л.Ганболдыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 дахь заалтад заасан "төрийн албанад З-аас доошгүй жил ажилласан" байх гэсэн шаардлагыг хангагүй болохыг тогтоосон байтал Л.Ганболдыг дахин Хөвсгөл аймгийн Засаг даргаар хууль зөрчин томилсон шалтгааны талаар.

Энэхүү асуултгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б.ПУРЭВДОРЖ

